

# **АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ЖУРАМ**

## **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, их засвар хийх инженерийн хийцтэй бүх төрлийн авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад мөрдөнө.

## **Хоёр. Ерөнхий зүйл**

Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1 “Барилгын ажил эхлүүлэх” гэж “Авто замын тухай” хуулийн 19; 20; 21 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг хангасны үндсэн дээр авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд /цаашид Гүйцэтгэгч гэх/-д барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

2.2 “Барилгын ажил үргэлжлүүлэх” гэж авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад тодорхой нөхцөл, шалтгааны улмаас Захиалагч болон техник технологийн хяналтын Зөвлөх, эсвэл мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, дүгнэлтээр 6 сараас дээш хугацаагаар барилгын ажил зогссон тохиолдолд уг зөрчил дутагдал арилсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтийг үндэслэн ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

2.3 “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах” гэж “Авто замын тухай” хуулийн 28.1; 28.2-т заасны дагуу эрх бүхий байгууллагаас томилсон Комисс ажиллаж, тухайн авто зам, замын байгууламжийг зураг төсөл, стандарт, техникийн шаардлагын дагуу баригдсан болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа талаар дүгнэлт гаргаж, тухайн авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрөх үйл ажиллагааг.

## **Гурав. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох**

3.1 Гүйцэтгэгч байгууллага авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх хүсэлт гаргахдаа энэхүү журмын Хавсралт 4.А-д заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн авто зам, замын байгууламжийн барилгын ажилд техник технологийн хяналт тавих эрх бүхий Зөвлөх /цаашид Зөвлөх гэх/- өөр хянуулан Захиалагчид хүргүүлнэ.

3.2 Захиалагч авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн баримт бичгийн бүрдэл шаардлага хангаж байгаа эсэхийг шалгаж, ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.3 Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг тухайн авто зам, замын байгууламж баригдаж дуусах хүртэлх гэрээнд заасан хугацаагаар олгоно.

3.4 Зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд барилгын ажил эхлээгүй тохиолдолд тухайн зөвшөөрөл хүчингүй болсонд тооцогдоно. Энэ тохиолдолд Захиалагчид ажил эхлүүлэх хүсэлтийг дахин гаргаж шийдвэрлүүлнэ.

#### **Дөрөв. Авто зам, замын байгууламжийн барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох**

4.1. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад дараах тохиолдолд барилгын ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл авна.

4.1.1 Авто зам, замын байгууламжийн ажил эхлүүлэх зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд ажил нь эхлээгүй;

4.1.2 Барилгын ажил дараах шалтгаанаар 6 сараас дээш хугацаагаар зогссон бол:

- Мэргэжлийн хяналтын болон хууль хяналтын байгууллагын шийдвэрээр ажлыг зогсоосон;

- Техник технологийн хяналтын Зөвлөхийн санал дүгнэлтэд үндэслэн Захиалагчийн шийдвэрээр ажлыг зогсоосон.

4.2. Дээрх үндэслэлээр барилгын ажил зогссон бол Гүйцэтгэгч энэхүү журмын Хавсралт 4.Б-д заасан баримт бичгийг бүрдүүлж, ажил зогсоосон шалтгаан, зөрчил дутагдлыг арилгасан тухай эрх бүхий байгууллагын дүгнэлтийн хамт ажил үргэлжлүүлэх хүсэлтийг Захиалагчид хүргүүлнэ. Захиалагч ирүүлсэн баримт бичгийг нягталж, шаардлага хангасан бол ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

#### **Тав. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах**

5.1. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах асуудлыг “Авто замын тухай” хуулийн 28.1, 28.2-т заасан эрх бүхий байгууллага хариуцан зохион байгуулж, ашиглалтад авах эсэх талаар дүгнэлт гаргах комисс /цаашид Комисс гэх/ томилно.

5.2. Гүйцэтгэгч авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлтийг Зөвлөхөөр хянуулан комисс томилох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

5.3. Комисс ажиллуулах хүсэлт гаргахдаа энэхүү журмын Хавсралт 4.В-д заасан баримт бичиг, холбогдох материалыг бүрдүүлсэн байна.

5.4. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь авто зам, замын байгууламжийн зориулалт, техник технологийн шийдэл, онцлог байдлаас хамааран энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр ажиллана.

5.5. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг комиссын нарийн бичгийн дарга, хяналтын Зөвлөх, Гүйцэтгэгчтэй хамтран зохион байгуулна.

5.6. Комиссын нарийн бичгийн дарга нь комиссын хуралдаан зохион байгуулах, гишүүдийн ирц бүрдүүлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, дүгнэлт /акт/-ийн төсөл боловсруулах, техникийн баримт бичгийн иж бүрдэлийг хангуулан архивт хүлээлгэн өгөх үүрэгтэй.

5.7. Зөвлөх нь энэхүү журмын Хавсралт 4.В-д заасан баримт бичгийг бүрдлийг хянаж комиссын нарийн бичгийн даргад хүргүүлнэ. Комиссын нарийн бичгийн дарга баримт бичгийн бүрдлийг шалгаж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах шаардлага хангасан тухай комиссын дарга болон гишүүдэд мэдэгдэнэ.

5.8. Комисс томилсон шийдвэрийн дагуу комисс ажиллахаар товлосон өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө комисс ажиллах газар, хугацаа, тухайн авто зам, замын байгууламжтай холбоотой мэдээллийг комиссын нийт гишүүдэд хүргүүлсэн байна.

5.9. Комиссын гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай комиссын дарга болон нарийн бичгийн даргад комисс ажиллахаас 1-ээс доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдсэн байна.

### **Зургаа. Комиссын эрх, үүрэг**

6.1 Комисс нь “Авто замын тухай” болон бусад хууль, тогтоомж, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, бусад техникийн баримт бичигт заасан шаардлага болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үүрэгтэй.

6.2 Комиссын нийт гишүүдийн санал дүгнэлтийг үндэслэн эцсийн шийдвэр гаргана. Энэхүү шийдвэр нь “Авто замын тухай” болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

6.3 Комисс нийт гишүүдийн 80-аас дээш хувийн ирц бүрдсэнээр ажиллана. Комиссын гишүүн хуралдаанд оролцох боломжгүй бол тухайн гишүүнийг томилсон байгууллагаас орлон ажиллах хүнийг томилно.

6.4 Комиссын гишүүд мэргэжлийн чиглэл, ажлын чиг үүргийн дагуу хариуцсан асуудал тус бүрээр санал дүгнэлтээ танилцуулж ажиллана. Үүнд:

6.4.1 Авто зам, замын байгууламжийг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх, гүйцэтгэлийн чанар, ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдал хангасан эсэх, зорчигчдын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх эсэх талаар нарийвчлан шалгах, дүгнэлт гаргах;

6.4.2 Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, баталгаажуулалт хийсэн байдлыг шалгах, нягтлах;

6.4.3 Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын хүрээнд хийгдсэн бусад байгууламж, төлбөр авах цэгийн барилга, суурилагдсан тоног төхөөрөмж, инженерийн нэмэлт шугам сүлжээний ажилд сорилт туршилт, тохируулга, зүгшрүүлэлт хийсэн байдал, стандартын шаардлага хангасан эсэх зэрэг ажил, үйлчилгээ явуулах, ашиглахад бэлэн эсэхийг шалгах, дүгнэх;

6.5 Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажил зураг төсөл, техникийн шаардлагын дауу хийгдээгүй буюу чанаргүй хийсэн, хууль тогтоомж, норм, дүрмийн заалт, стандартын шаардлага зөрчсөн бол ашиглалтад авахыг тодорхой хугацаагаар хойшлуулж, ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагаар шалгуулах, хөндлөнгийн дүгнэлт гаргуулах зэрэг асуудлыг шийдвэрлүүлнэ.

6.6 “Авто замын тухай” хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, барилгын норм, нормативын бичиг, баримтын заалтыг ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Гүйцэтгэгч, Зөвлөх, зураг төслийн байгууллагад хариуцлага тооцох, тусгай зөвшөөрлийн эрх цуцлуулах зэрэг саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

6.7 Авто зам, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлтийн ажлыг дутуу буюу чанаргүй хийсэн, хууль тогтоомж, норм, дүрэм, стандарт, зураг төсөл, техникийн нөхцөл шаардлагыг хангаагүй, барилгын ажлын явц, чанарт Захиалагч болон Зөвлөх, мэргэжлийн хяналтын байгууллагуудаас тавьсан шаардлага, дүгнэлтийг биелүүлээгүй тохиолдолд комисс ажиллахаас татгалзана.

6.8 Комисс нь авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад авах, авто тээврийн хөдөлгөөн нээх шийдвэр гаргаж болно.

6.9 Авто зам, замын байгууламжийн барилгын ажил нь зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн эсэхэд эргэлзээ гарсан тохиолдолд Комиссын шийдвэрээр тухайн барилга, байгууламжид иж бүрнээр болон хэсэгчлэн чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийж болно.

6.10 Комиссын гишүүд зураг төсөл, техникийн шаардлагын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах талаар шаардлагатай үүрэг чиглэл өгч, гүйцэтгэлийн биелэлтийг комиссын хуралдаанд танилцуулан нэгдсэн зөвшилцөлд хүрсэн тохиолдолд энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна.

6.11 Комиссын хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хурлын протоколд тэмдэглэж, Гүйцэтгэгч заасан хугацаанд чанартай гүйцэтгэж, биелэлтийг тайлагнах бөгөөд ажлын гүйцэтгэлийн чанарт Зөвлөх болон зам хариуцагч байгууллага хяналт тавьж ажиллана.

6.12 Комиссын акт баталгаажаагүй, архивын материалыг шаардлагын дагуу бүрдүүлж архивт хүлээлгэж өгөөгүй байхад Гүйцэтгэгч болон Зөвлөхийн эцсийн шатны санхүүжилт олгохыг хориглоно.

### **Долоо. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник технологийн хяналтын Зөвлөхийн эрх, үүрэг**

7.1 Зөвлөх нь авто зам, замын байгууламжийн барилгын ажил бүрэн дууссан тухай мэдэгдэх хуудас болон Комисс ажиллуулах хүсэлтийг Захиалагчид хүргүүлнэ.

7.2 Барилгын ажлын үе шатны хяналтын болон Захиалагчийн албан шаардлага, комиссоос өгсөн үүрэг даалгавар, дүгнэлтийн биелэлтийг Гүйцэтгэгчтэй хамтран гаргаж холбогдох мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан комисст хүргүүлнэ.

7.3 Зөвлөх нь тухайн авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаанд тухайн замын чанар байдалд гэрээнд заасны дагуу үзлэг хийж, дүгнэлт гаргаж, Захиалагчид ирүүлнэ.

7.4 Гүйцэтгэлийн чанар, технологийн алдаанаас үүссэн эвдрэл гэмтлийг Гүйцэтгэгч засварлах үйл ажиллагаанд хяналт тавьж, чанарыг баталгаажуулна.

7.5 Авто зам, замын байгууламжийн ажил дутуу, чанаргүй хийгдсэнээс комисс дахин ажиллуулах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг хариуцна.

### **Найм. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

8.1. Авто зам, замын байгууламжийг зураг төсөл, стандарт, техникийн шаардлагын дагуу чанартай гүйцэтгэж, Комиссын дүгнэлт, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгана.

8.2. “Авто замын тухай” хуулийн 28.4 дэх хэсэгт чанарын баталгаат хугацаа 3 жил байхаар заасны дагуу Гүйцэтгэгч түүний чанарыг хариуцах талаар баталгаа гаргаж, Зөвлөхөөр хянуулан Захиалагчид хүлээлгэн өгнө.

8.3. Ашиглалтад орсон тухайн барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичгийн бүрдэлийг бүрэн хангаж, батлагдсан маягтын дагуу замын паспорт, гүүр, хоолойн картыг үнэн зөв хөтөлж, цаасан болон файл хэлбэрээр авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагын архивд хүлээлгэж өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

### **Ес. Баталгаат хугацаа, барьцаа хөрөнгө суллах**

9.1 Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгаат хугацаа 3 жил байх бөгөөд Гүйцэтгэгч, Зөвлөх этгээдүүд уг хугацаанд тухайн

замд илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтэлийг бүрэн хариуцна.

9.2 Баталгаат засварын хугацааг Захиалагч эсвэл ашиглалтад авах Комиссын дүгнэлт, шийдвэрээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нээсэн өдрөөс эхлэн тооцно.

9.3 Баталгаат хугацаа дууссаны дараа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, тухайн авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авах чиг үүргийг хэрэгжүүлэгч энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн барьцаа хөрөнгийг суллана. Үүнд:

9.3.1 Баталгаат засварын хугацаанд хийгдсэн ажлын тайлан

9.3.2 Техник технологийн хяналтын Зөвлөхийн дүгнэлт

9.3.3 Зам хариуцагч байгууллагын зөвшөөрөл

9.4 Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авсан комиссын акт гарснаар Гүйцэтгэгчийн барьцаа хөрөнгийн 50 хувийг, баталгаат хугацаа дууссаны дараа үлдэгдэл 50 хувийг олгоно.

9.5 Авто зам, замын байгууламжийг хэсэгчлэн ашиглалтад оруулсан тохиолдолд тухайн хэсэгт баталгаат хугацааг тооцно.

#### **Арав. Хүлээх хариуцлага**

10.1 Авто зам, замын байгууламжийн барилгыг ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцад барилгын ажлын талаар худал мэдээлэл өгсөн талууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

10.2 Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах үед гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн архивын материалын бүрдэлтэнд хяналт тавьж ажиллах бөгөөд бүрдэл дутуу материал хүлээн авсан тохиолдолд тухайн мэргэжилтэн болон архивын ажилтанд хариуцлага тооцно.

-oOo-

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 1 дүгээр хавсралт

## **АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ**

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

№

Авто зам, замын байгууламж түүний туслах барилгуудын нэр төрөл, хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц:

Захиалагчийн нэр:

Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгчийн нэр, хаяг:

Газар олгосон шийдвэр (захирамж), байршил:

Гүйцэтгэгч байгууллагын нэр, Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн дугаар, хаяг, холбоо барих утас:

Зураг төсөл зохиогч байгууллагын нэр, хаяг, зургийн шифр:

Зөвшөөрөл олгосон үе шатны ажлын нэр:

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:

Зөвшөөрөл олгосон албан тушаалтан:

Овог нэр, гарын үсэг, тамга тэмдэг

Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:

Онцгойлон заах нөхцөл:

Зөвшөөрөл олгогч байгууллагын тусгай тэмдэглэл:

## **ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАЛТ**

20 ... оны ... -р сарын ... -ны өдөр

Дуусах үед нь зөвшөөрөл олгогчид заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд:

Онцгойлон заах нөхцөл:

Зөвшөөрөл сунгасан ажлын нэр төрөл

Сунгасан хүчинтэй хугацаа

Хугацаа сунгасан байгууллагын нэр:

Хугацаа сунгасан албан тушаалтан:

Овог, нэр, хаяг, гарын үсэг, тэмдэг

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 2 дугаар хавсралт

## АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН АКТ, ДҮГНЭЛТ

20 ... оны ... сарын  
... -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

НЭГ.

- 1.1. Авто зам, замын байгууламжийн нэр, байршил, хүчин чадал
- 1.2. Захиалагч байгууллага, нэр, хаяг:
- 1.3. Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгчийн нэр, хаяг:
- 1.4. Зам хариуцагч байгууллагын нэр, хаяг:
- 1.5. Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг:
- 1.6. Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, зураг төслийн шифр, дугаар:

1.7. ....  
шийдвэрээр зохион байгуулсан хүний ..... бүрэлдэхүүнтэй Комисс нь уг барилга байгууламжийг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай ..... байгууллагын 20 ... оны ... сарын ... -ны өдрийн ... дугаар мэдэгдлийн дагуу 20... оны ... сарын ... -ны өдрөөс ...-ны өдөрт багтаан шинээр барьсан/их засвар/ шинэчлэлтийн ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.7. Энэхүү авто зам, замын байгууламжийг ... дугаартай зураг төслөөр ... оны ... сараас барьж эхэлсэн бөгөөд ... оны ... сарын ... -ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР.

2.1. Энэхүү ..... авто зам, замын байгууламж, холбогдох бичиг, баримт, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсөний үндсэн дээр ашиглалтад оруулах комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2.2. Энэхүү авто зам, замын байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж .....

зориулалтаар ашиглахад ..... гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болох .....мэдэлд 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс ашиглалтад оруулахыг зөвшөөрөв.

2.3. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан Комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

1. “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын Хавсралт 4.В-д заасан баримт бичгүүдийн бүрдлийг хангаж, тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагын архивд ... хоногийн дотор хүлээлгэж өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх.

2. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгааны 3 жилийн хугацаанд тухайн замд илэрсэн барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтэлийг бүрэн хариуцах.

Зам хариуцагч (ашиглагч) байгууллагад:

1. “Авто замын тухай” хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдээллийн санд баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх;

2. “Авто замын тухай” хуулийн 23.3.-т заасны дагуу чанарын баталгаат хугацаа дууссанаас хойшхи авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

3. Комиссын акт ... хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн бичиг, баримтын жагсаалтыг хавсаргав.

## ГУРАВ. АКТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

.....  
(Тухайн авто зам, замын байгууламжийн нэр, байршил, хүчин чадал)-г ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

**КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:**

Комиссын дарга:

Нарийн бичгийн дарга:

Гишүүд:

Тайлбар: Энэхүү хуудсанд комисст ажилласан гишүүдийн нэр багтаагүй тохиолдолд дараагийн хуудсанд үргэлжлүүлэн бичихдээ дээр нь тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

----- оОо -----



“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг  
эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын  
3 дугаар хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ,  
ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, АШИГЛАЛТАД ОРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХ БАЙГУУЛЛАГА БОЛОН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

№	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага	Ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн		
			Дарга	Нарийн бичгийн дарга	Гишүүд
1	<p>1. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламж</p> <p>2. Их засвар, шинэчлэлт хийсэн олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламж</p> <p>3. Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж</p>	Салбарын төрийн захиргааны төв байгууллага	Салбарын төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга	Салбарын төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтэн	<p>1. Захиалагчийн төлөөлөл</p> <p>2. Техник технологийн хяналтын Зөвлөхийн төлөөлөл</p> <p>3. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл</p> <p>4. Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл</p> <p>5. Төрийн захиргааны байгууллагын бүртгэл мэдээллийн сан хариуцсан ажилтан</p> <p>6. Зам хариуцагч байгууллагын төлөөлөл</p> <p>7. Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл</p> <p>8. Замын цагдаагийн газрын төлөөлөл</p> <p>9. Салбарын мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</p> <p>10. Орон нутгийн засаг захиргааны байгууллагын авто замын асуудал хариуцсан ажилтан</p>

№	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага	Ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн		
			Дарга	Нарийн бичгийн дарга	Гишүүд
2	<p>1. Нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж</p> <p>2. Их засвар, шинэчлэл хийсэн нийслэл, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа авто замын асуудал эрхэлсэн агентлаг</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа авто замын асуудал эрхэлсэн агентлагийн холбогдох газар, хэлтсийн дарга</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын харьяа авто замын асуудал эрхэлсэн агентлагийн мэргэжилтэн</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Захиалагчийн төлөөлөл</li> <li>2. Техник технологийн хяналтын Зөвлөхийн төлөөлөл</li> <li>3. Зураг төсөл зохиогч байгууллагын төлөөлөл</li> <li>4. Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл</li> <li>5. Орон нутгийн захиргааны байгууллагын замын бүртгэл мэдээллийн сан хариуцсан ажилтан</li> <li>6. Зам хариуцагч байгууллагын төлөөлөл</li> <li>7. Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагын төлөөлөл</li> <li>8. Аймаг, нийслэлийн замын цагдаагийн газрын төлөөлөл</li> <li>9. Аймаг, нийслэлийн салбарын мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөл</li> <li>10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл</li> </ol>

№	Авто зам, замын байгууламжийн зориулалт, ангилал	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох, ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага	Ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн		
			Дарга	Нарийн бичгийн дарга	Гишүүд
3	Аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам, замын байгууламж	Захиалагч байгууллага	Зөвшилцсөнөөр	Зөвшилцсөнөөр	Зөвшилцсөнөөр

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 4 дүгээр хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ БОЛОН АШИГЛАЛТАД ОРУУЛАХАД БҮРДҮҮЛСЭН БАЙХ ШААРДЛАГАТАЙ БИЧИГ, БАРИМТЫН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх бичиг, баримт
<b><u>А. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт</u></b>	
1.	Гүйцэтгэгч байгууллагын ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг
2.	Гүйцэтгэгч байгууллагын улсын бүртгэлийн болон авто зам, замын байгууламжийн барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
3.	Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
4.	Улаан шугам хүлээлцсэн акт
3.	Магадлал хийгдсэн тухайн авто зам, замын байгууламжийн иж бүрэн зураг төсөл, Экспертизийн дүгнэлт
4.	Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажилд захиалагчийн техник, технологийн хяналт гүйцэтгэх этгээдтэй байгуулсан гэрээ
5.	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээс газар олгосон шийдвэр, техникийн нөхцөлүүд
6.	Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий байдлын үнэлгээ, шаардлагатай бол байгаль орчин нөлөөлөх байдлыг албажуулсан нарийвчилсан үнэлгээ
7.	Археологийн тандалт, судалгааны тайлан
<b><u>Б. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэх зөвшөөрөл олгоход бүрдүүлэх бичиг, баримт</u></b>	
1.	Ажил үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн Гүйцэтгэгчийн албан хүсэлт
2.	Ажил зогсоох шийдвэр гаргасан холбогдох эрх бүхий байгууллагын ажил үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн шийдвэр, дүгнэлт
3.	Зөрчил арилсан тухай баримт, хийсэн ажлын тайлан
<b><u>В. Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулахад бүрдүүлэх, архивт хүлээлгэн өгөх бичиг, баримт</u></b>	
1.	Захиалагчтай байгуулсан гэрээ /эх хувь/, нэмэлт гэрээ
2.	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл
3.	“Авто замын тухай” хуулийн 4.1.18.-д заасан зураг төслийн иж бүрдэл /эх хувь/
4.	Улаан шугам хүлээлцсэн акт
5.	Комисс ажиллуулах хүсэлт гаргасан албан бичиг, комиссын хурлын тэмдэглэл, баталгаажсан акт, гишүүдийн саналын хуудас
6.	Гэрээ дүгнэсэн акт /эх хувь/
7.	Санхүүжилтын гүйцэтгэл /тооцоо нийлсэн акт
8.	Гүйцэтгэлийн зураг
9.	Археологийн авран хамгаалах ажлын тайлан /эх хувь/

10.	Геодезийн хэмжилтийн материал
11.	Лабораторийн шинжилгээний дүгнэлтүүд
12.	Засаг даргын газар олгосон захирамж, карьеруудыг нөхөн сэргээсэн акт /байгаль орчны улсын байцаагчийн гарын үсэгтэй/
13.	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан /эх хувь/
14.	Замын бүртгэл мэдээллийн паспорт, гүүр, хоолойн карт /цаасан болон файл хэлбэрээр/ 4%
15.	Зөвлөх багийн эхлэлийн, явцын, эцсийн шатны тайлан, шаардлага, дүгнэлт, түүний биелэлт, Голлон ажилласан замын инженер, техникийн ажилтнуудын анкет, Зөвшөөрөл авах хүсэлтүүд, Гэрэл зургийн цомог, Ирсэн болон явуулсан албан бичиг, хурлын тэмдэглэлүүд, талбайн уулзалтын тэмдэглэл /он сарын дарааллаар/
16.	Тухайн барилга, байгууламжид Техник ашиглалтын түвшин тогтоох, чанар байдлын дүгнэлт гаргах судалгаа хийгдсэн тохиолдолд гарсан дүгнэлт (замын тэгш байдалын үзүүлэлт, хучилтын бат бэх, гадаргуугийн гулсалтын эсэргүүцэл, гадаргуугийн дугуй мөрний хотойлт, гадаргуугийн барзгаржилт, далан суурийн даац, хурдны хангалт г.м)

“Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын 5 дугаар хавсралт

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГЫН АЖИЛ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

Авто зам, замын байгууламжийн нэр, хүчин чадал:

.....

Авто зам, замын байгууламж барих газар олгосон байгууллагын нэр, шийдвэрийн он, сар, өдөр, дугаар:

.....

Уг авто зам, замын байгууламжийн зураг төслийг боловсруулсан байгууллага, тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа:

.....

Зураг төсөл, техникийн баримт бичгийн иж бүрдэл.....

ГҮЙЦЭТГЭГЧИЙН: Нэр, харилцах утас.....

Харилцах банк, дансны дугаар .....

Тусгай зөвшөөрлийн дугаар, ажлын нэр, төрөл .....

.....

.....

Зөвшөөрлийн олгосон он, сар, өдөр, хүчинтэй байх хугацаа

.....

Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг гүйцэтгэх ИТА-ны талаарх мэдээлэл .....

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний сар, өдөр, дугаар

.....

.....

Зураг төсөл зохиогчийн овог нэр, ажлын хаяг, утасны дугаар

.....

Техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээг эрхлэгчийн нэр, хаяг, харилцах утас, гэрээний огноо, дугаар

.....

Иймд барилга угсралтын ажлыг иж бүрдлээр/хэсэгчилсэн ажлуудаар аль нь болохыг бичнэ.

20.....он.....-р сарын .....-ны өдрөөс 20..... оны .....-р сарын .....-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэх зөвшөөрөл олгоно уу. /Барилга угсралтын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх бол ажлын төрлийг нэр заан бичнэ/

Тус өргөдөлд дурдагдсан болон түүнд орох бүх өөрчлөлт, бусад холбогдох асуудлыг гүйцэтгэгч бүрэн хариуцна. Энэ талаар гарсан ямар нэг асуудлыг тухайн үед нь зөвшөөрөл олгосон газарт тухай бүрд мэдэгдэж байх болно.

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

---

албан тушаал, овог нэр, гарын үсэг